ХАРХОРИН СУМ

# БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БААТАРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 он

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

## БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.БААТАРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахад төр, иргэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, арга зүй удирдлагаар хангаж ажиллах”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 1 | Бүх нийтийн мод тарих хөдөлгөөн өрнүүлэх тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулах хүрээнд ажилд байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн талбайд 300 ширхэг, тариалангийн талбайн хашаанд 500 ширхэг, айл өрхүүд 1200 ширхэг, ААН, байгууллагууд өөрийн эзэмшил газартаа 6060 ширхэг, нийт 8060 ширхэг мод бут тарьлаа.<br>Орхоны хөндийн байгалийн цогцолборт | 2025.05.11-2025.05.25 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын хамгаалатын захиргаанаас Мойлтын аманд ойжуулалтын 12.5 га талбайд 8000 ширхэг мод тарьсан. Шинэ Хархорин хотын захиргаанаас Онгоцон ухаа багийн нутаг Харгантад 1000000 мод тарих хайс хашаа барих, усалгааны 40 ширхэг гүний худаг гаргах ажил өрнөж байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2 Мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх . | -Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн байдал | 1 | 1 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулах хүрээнд бүх нийтийн мод тарих ажлыг 5 дугаар сард зохион байгуулж айл өрхүүд 1200 ширхэг, ААН, байгууллагууд өөрийн эзэмшил газартаа 6060 ширхэг мод тарьж, мод тарихад шаардагдах 2 хово машин хар шороо бэлтгэж мод тарих арга зүйн зөвлөгөө, зөвлөмж мэдээлэл хүргэсэн | 2025.05.11-2025.05.25 | 95 |
| 3. | Арга хэмжээ 1.3 Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг иргэдэд сурталчлан таниулах, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | Зохион байгуулах арга хэмжээний тоо | | | Орхон, Шанх, Нарийн хүр багийн ойн сан бүхий газар нутгаар сумын ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс, ОХБЦГХ-ын захиргааны байгаль хамгаалагчтай хамтран болзошгүй ой хээрийн болон ахуйн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 85 өрхийн 230 гаруй иргэдэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2 | 2 | мэдээ мэдээлэл хүргэсэн. 85 өрхтэй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагын гэрээ байгуулсан. Мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх 2 ширхэг самбар байршуулсан.. Сумын төвийн багийн Засаг дарга болон тохижилтын албаны ажилтан нартай хамтарч сумын төвийн айл өрхүүдэд 2000 ширхэг хог ангилан ялгах брошур тараасан. | 2025.05.11-2025.05.25 | 95 |
| 4 | Арга хэмжээ 1.4<br>Ойн хортон хөнөөлт шавьжийн устгал тэмцлийн ажил гүйцэтгэх | Хортон устгал хийгдсэн талбайн хэмжээ | 620 | 675 | Улсын төсвийн Хөрөнгө оруулалтаар Орхон, Нарийн хүр, Шанх багийн ойн сан бүхий 3000 га талбайд ойн хортон шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулж 9 нислэг хийсэн. Байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 27.0 сая төгрөгийн санхүүжилтээр Шанхын нуруу, Цагдуулт гэх газрын 675 га ойн сан бүхий талбайд ойн хортон шавьжтай тэмцэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендер зарласан. | 2025.06.07-2025.07.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 1.5<br>Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ, байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах | Сургалт сурталчилгааны тоогоор | 1 | 1 | Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхэд залуучууд ЕБС-ийн сурагчдын дунд Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Өвөрхангай аймгийн Байгаль орчны газар, Орон нутгийн өмчит Хархорин-Ус суваг ХХК, Засаг даргын Тамгын газар хамтарч ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан байгаль орчны багц сургалтыг зохион байгуулсан.<br>Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Хархорин сумын нийт иргэдийн дунд "Мөнх цас, мөсөн голыг хамгаалан авч үлдье" сэдэвт видео контентын уралдаан зохион байгуулж эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшууллаа..<br>1-р байрт Хархорин сумын ЕБС-ын 2-р сургуулийн 12б ангийн хамт олон.<br>2-р байрт Хархорин сумын ЕБС-ын 2-р сургуулийн 11а ангийн хамт олон. | 2025.03.11-2025.03.22 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3-р байрт Хархорин сумын иргэн Б.Орхонцэцэг тус тус шалгарлаа. | | |
| 7 | Арга хэмжээ 1.7<br>Сумын хэмжээнд байгаа агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл, нүхэн жорлонгийн тооллогыг зохион байгуулах | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 1 | Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл улс орон даяар явагдаж Хархорин сумын хэмжээнд 3-15 квт хүчин чадалтай зуух 1325, 15-100 квт хүчин чадалтай зуух 34, 100-4200 квт хүчин чадалтай зуух 16 бүртгэгдэж зуух тус бүрийн судалгааг мэдээллийн санд оруулж нэгтгэлийг Өвөрхангай аймгийн УЦУОШГазарт хүргүүсэн.<br>Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоолгохоор шаардагдах баримт бичгийг бүрдүүлж холбогдох газарт хүргүүлсэн. | 2025.03.11-2025.03.22 | 90 |
| 8 | Арга хэмжээ 1.8<br>Амьтны амьдрах орчныг сайжруулах, өсгөн үржүүлэх, нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, биотехникийн арга хэмжээ авах | Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авсан байдал, үр дүн, | 3 | 3 | БОНСАХЗардлаас 1,500,000 төгрөг төсөвлөн Жалбаа багийн Их эрээн уулын зэрлэг амьтдад 3 Орхон баггийн Баянзүрх хайрханы 2 цэгт 45 боодол өвс, 600 кг хужир тавьж биотехникийн арга хэмжээ авлаа. | 2025.01.15-2025.02.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | давтамж, цэгийн тоо хэмжээгээр | | | | | |
| Зорилт 2. Зорилт 2. "Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>Хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан, бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах | Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 2 | Сумын төвийн багийн Засаг дарга болон тохижилтын . албаны ажилтан нартай хамтарч сумын төвийн айл өрхүүдэд 2000 ширхэг хог ангилан ялгах брошур тараасан.<br><br>Сумын төвөөс Долоон бургас хүртэлх Туркийн замын 2 тийш 50 м дэхь 15 км газрын хог хаягдлыг Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 4 сарын 14-15 өдрүүдэд зохион байгуулсан.<br><br>Бүх нийтийн их цэвэрлэгээг 2024 оны 04 дүгээр сарйн 25-26 өдрүүдэд зохион байгуулж, 35 байгууллагын 360 гаруй албан хаагчид байгууллагынхаа эргэн тойрон болон хуваарьт талбайг айл өрхүүд хашааныхаа урд болон ар хэсгийг цэвэрлэж 28 тонн | 2025.04.01-2025.04.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хог хаялдлын сумын төвийн нэгдсэн хогийн цэгт буулгасан.<br><br>Хөгшин Орхон голын ай сав газрын онцгой хамгаалалтын бүс дэх хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулжХөгшин Орхон голын эхээс Хашаат сумын хилийн зааг хүртэл нийт 40 км газарт тархсан хог хаягдыг цэвэрлэх ажилд сумын 20 төрийн байгууллагын нийт 300 гаруй албан хаагчид оролцож, 18 тонн хог хаягдлыг цуглуулж, сумын нэгдсэн хогийн цэгт төвлөрүүллээ. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Сумын төвүүдэд энгийн хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээг багасгах | Сумын төвлөрсөн хогийн цэгийн хэмжээ багассан байна | 5 га | 5 га | Орон нутгийн төсвийн 3.6 сая төгрөгийн санхүүжилтээр сумын төвийн нэгдсэн хогийн цэгт түрэлт хийх, ландфиллын аргаар дарж булшлах ажлыг 2.4.6 дугаар сарууддад 3 удаа зохион байгуулсан. | 2025.02.15-2025.06.10 | 100 |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. "Байгаль орчны хяналт шалгалтын чиглэлээр"** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1<br>Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх таслан зогсоох, цаг үеийн шинж чанартай эргүүл хяналт шалгалтыг зохион байгуулах | Төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо | 2 | 2 | Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх таслан зогсоох хуулийн хэрэгжилтийн хангах зорилгоор төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 6 удаа хийж гүйцэтгэн Амьтны тухай хууль зөрчсөн 1 иргэнд 300.000 төгрөгийн шийтгэл оногдуулж 454.000 төгрөгийн нөхөн төлбөр тогтоосон. | 2025.01.15-2025.06.10 | 90 |
| | | Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоо | 6 | 6 | | | |
| 2 | Арга хэмжээ 3.2<br>Бэлчээрийн мэрэгчтэй энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх, устгах ажилд хяналт тавих | бэлчээрийн мэрэгчтэй тэмцэх | 8000 га | 4900 га | Хархорин сумын Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар захирамжаар улсын төсвийн 50,4 сая, орон нутгийн хөгжлийн сангийн 20.0 сая, төгрөгний санхүүжилтээр Хархорин сумын 4900 га бэлчээрт бэлчээрийн мэрэгчтэй микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулж 88,2 хувийн үр дүнтэй хүлээлгэн өгсөн. | 2025.04.14-2025.04.16 | 88.2 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Өвөрхангай айигийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний дагуу мод тарилт, ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлээний ажилд 10 иргэнийг ажиллуулах | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Өвөрхангай айигийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний дагуу мод тарилт, ногоон байгууламжийн арчилгаа цэвэрлээний ажилд 10 иргэнийг 8 хоногийн хугацаанд ажиллуулж сумын төвийн 10 га ногоон байгууламжийн хог хаягдлын цэвэрлэх, хайс хашааг засах ажлыг зохион байгуулсан. | 2025.05.30-2025.06.10 | 100 |
| 2 | Хангай хайрханы тахилгын арга хэмжээг зохион хэмжээнд морины комисст ажилласан | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 1 | 1 | Хангай хайрханы тахилгад 3 насны 70 орчим хурдан морины сэрвээний өндөр хэмжсэн | 2025.06.04 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. 1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль зэргийг судлах | Байгаль орчныг хамгаалах багц хуулийн шинэчилсэн | - | - | Байгаль орчныг хамгаалах багц хуулиудыг судалж, хэрэгжилтэнд хяналт тавин, илэрсэн зөрчлийг таслан зогсоон, хуулийн дагуу арга | 2025.01.01-2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | найруулгыг судлах | | | хэмжээ авч зөрчлийг арилгасан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>ТАХ –ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг,хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт,шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | ТАХ ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаандаа тайлагнах | ТАХ ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж эхний хагас жилийн биелэлтийг тайлагнасан байна | ТАХ ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж эхний хагас жилийн биелэлтийг тайлагнасан байна | ТАХ –ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг,хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт,шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн | 2025.01.01-2025.06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн | ................................ /Ц.Баатарсүрэн / | 2025.06.10 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |